

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн
хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/36/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 70432545

цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 3 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 3 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 3 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 5 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 5 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 6 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 7 |
| 3. Аудитын тайлан..... | 8 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 8 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 8 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 9 |
| 3.4 Материаллаг байдал | 9 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 10 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 10 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 11 |
| 3.8 Аудитын гол асуудал | 11 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 11 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 11 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 11 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 12 |
| 4. Аудитын илрүүлэлт | 12 |
| 4.1 Залруулсан алдаа..... | 12 |
| 4.2 Төлбөрийн акт..... | 12 |
| 4.3 Зөвлөмж | 12 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 12 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| НА | Нотлох ажил |



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХАР УС НУУР ОРЧМЫН УТХГНХЗ-НЫ
ДАРГА С.БАТМӨНХ ТАНАА

2022.02.09 № 2/11
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



021020228

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>13,270,972.06</u> | <u>12,002,000.00</u> |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 13,270,972.06 | 12,002,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 13,270,972.06 | 12,002,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,270,972.06 | 12,002,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>593,291,150.06</u> | <u>553,716,117.35</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 593,291,150.06 | 553,716,117.35 |
| 392 | Биет хөрөнгө | 562,723,150.06 | 523,248,117.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 417,081,757.00 | 445,001,757.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -24,797,360.62 | -39,211,137.75 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 137,264,692.89 | 137,264,692.89 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -34,911,670.57 | -67,522,103.89 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 47,554,550.81 | 56,406,550.81 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -23,337,825.88 | -41,573,248.39 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,867,518.43 | 13,440,068.43 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -4,337,589.85 | -7,560,446.32 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 51,263,900.00 | 51,263,900.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -11,924,822.15 | -24,261,915.47 |
| 393 | Биет бус хөрөнгө | 30,568,000.00 | 30,468,000.04 |
| 39301 | Программ хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 30,168,000.00 | 30,168,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II | <u>606,562,122.12</u> | <u>565,718,117.35</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>606,562,122.12</u> | <u>565,718,117.35</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 606,562,122.12 | 565,718,117.35 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 794,074,428.00 | 794,074,428.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 794,074,428.00 | 794,074,428.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | - | -271,569,232.17 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 230,725,227.40 | -230,725,227.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -40,844,004.77 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 43,212,921.52 | 43,212,921.52 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>606,562,122.12</u> | <u>565,718,117.35</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 482,686,607.00 | 479,998,890.75 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 00.00 | 00.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 41,652,500.00 | 26,981,132.75 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 41,652,500.00 | 26,981,132.75 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,898,000.00 | 4,930,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,898,000.00 | 4,930,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 22,051,132.75 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 441,034,107.00 | 453,017,758.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 384,175,200.00 | 439,586,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 384,175,200.00 | 439,586,100.00 |

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 56,858,907.00 | 13,431,658.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 12,091,658.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 56,788,907.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 70,000.00 | 1,340,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 446,007,854.63 | 520,842,895.52 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 446,007,854.63 | 520,842,895.52 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 429,150,160.63 | 448,080,996.52 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 233,616,806.00 | 232,381,204.51 |
| 210101 | Үндсэн цалин | 178,165,353.00 | 171,151,228.79 |
| 210102 | Нэмэгдэл | 40,126,853.00 | 48,920,311.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,324,600.00 | 12,309,664.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,548,900.00 | 30,245,931.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,153,600.00 | 20,850,731.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,348,900.00 | 2,348,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,879,100.00 | 1,879,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 469,700.00 | 469,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,697,600.00 | 4,697,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,169,772.00 | 25,318,753.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 23,530,200.00 | 20,862,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 519,700.00 | 419,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,119,872.00 | 4,036,553.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,820,125.00 | 25,926,092.06 |
| 210401 | Бичиг хэрэг | 889,250.00 | 763,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,157,600.00 | 12,761,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,216,575.00 | 847,220.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 72,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 484,700.00 | 1,283,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 10,270,972.06 |
| 2105 | Нормативт зардал | 871,200.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 871,200.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,005,800.00 | 903,312.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 471,200.00 | 374,592.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 534,600.00 | 528,720.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,780,900.00 | 2,363,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,780,900.00 | 2,363,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 54,991,741.40 | 55,558,980.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 53,380,241.40 | 54,207,260.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 158,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 742,500.00 | 742,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 219,900.00 | 161,820.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 49,500.00 | 39,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 242,000.00 | 250,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 33,600.00 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,344,916.23 | 75,383,223.46 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 870,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,931,500.00 | 1,160,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 53,413,416.23 | 73,352,823.46 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 16,857,694.00 | 72,761,899.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 56,932,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 56,932,500.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 16,857,694.00 | 15,829,399.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,857,694.00 | 15,829,399.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 36,678,752.37 | -40,844,004.77 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 36,678,752.37 | -40,844,004.77 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|------------------------|---|
| C01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 794,074,428.00 | 44,455,489.35 | -308,466,446.22 | 530,063,471.13 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 794,074,428.00 | 44,455,489.35 | -308,466,446.22 | 530,063,471.13 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -12,629,497.37 | -12,629,497.37 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 794,074,428.00 | 43,212,921.52 | -230,725,227.40 | 606,562,122.12 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 794,074,428.00 | 43,212,921.52 | -230,725,227.40 | 606,562,122.12 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 794,074,428.00 | 43,212,921.52 | -230,725,227.40 | 606,562,122.12 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -40,844,004.77 | -40,844,004.77 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 794,074,428.00 | 43,212,921.52 | -271,569,232.17 | 565,718,117.35 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 445,932,107.00 | 457,947,758.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,898,000.00 | 4,930,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,898,000.00 | 4,930,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,898,000.00 | 4,930,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,898,000.00 | 4,930,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 441,034,107.00 | 453,017,758.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 384,175,200.00 | 439,586,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 384,175,200.00 | 439,586,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 56,858,907.00 | 13,431,658.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 12,091,658.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 56,788,907.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 70,000.00 | 1,340,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 445,932,107.00 | 457,947,758.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 445,932,107.00 | 457,947,758.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 429,074,413.00 | 385,185,859.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 233,616,806.00 | 232,381,204.51 |
| 210101 | Үндсэн цалин | 178,165,353.00 | 171,151,228.79 |
| 210102 | Нэмэгдэл | 40,126,853.00 | 48,920,311.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,324,600.00 | 12,309,664.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,548,900.00 | 30,245,931.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,153,600.00 | 20,850,731.49 |

| | | | |
|-------------|--|-----------------------|----------------------|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,348,900.00 | 2,348,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,879,100.00 | 1,879,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 469,700.00 | 469,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,697,600.00 | 4,697,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,169,772.00 | 25,318,753.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 23,530,200.00 | 20,862,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 519,700.00 | 419,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,119,872.00 | 4,036,553.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,820,125.00 | 15,290,120.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 889,250.00 | 763,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,157,600.00 | 12,396,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,216,575.00 | 847,220.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 72,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 484,700.00 | 1,283,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 871,200.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 871,200.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,005,800.00 | 903,312.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 471,200.00 | 374,592.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 534,600.00 | 528,720.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,780,900.00 | 2,363,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,780,900.00 | 2,363,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 108,329,410.00 | 64,560,980.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 106,717,910.00 | 63,209,260.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 158,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 742,500.00 | 742,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 219,900.00 | 161,820.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 49,500.00 | 39,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 242,000.00 | 250,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 33,600.00 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,931,500.00 | 14,122,058.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 12,961,658.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,931,500.00 | 1,160,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 16,857,694.00 | 72,761,899.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 56,932,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 56,932,500.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 16,857,694.00 | 15,829,399.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,857,694.00 | 15,829,399.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|-----------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |

| | | | |
|---------------|--|----------------|----------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 444,386,100.00 | 428,686,701.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 444,386,100.00 | 428,686,701.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 387,453,600.00 | 371,754,201.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 234,879,900.00 | 232,381,204.51 |
| 210101 | Үндсэн цалин | 173,081,100.00 | 171,151,228.79 |
| 210102 | Нэмэгдэл | 49,274,200.00 | 48,920,311.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,524,600.00 | 12,309,664.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,708,800.00 | 30,245,931.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,313,600.00 | 20,850,731.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,348,800.00 | 2,348,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,879,000.00 | 1,879,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 469,800.00 | 469,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,697,600.00 | 4,697,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25,306,100.00 | 24,848,753.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,392,900.00 | 20,392,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 467,800.00 | 419,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,445,400.00 | 4,036,553.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,828,900.00 | 15,290,120.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 763,500.00 | 763,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,396,400.00 | 12,396,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,386,000.00 | 847,220.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,283,000.00 | 1,283,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 911,600.00 | 903,312.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 377,000.00 | 374,592.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 534,600.00 | 528,720.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,384,700.00 | 2,363,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,384,700.00 | 2,363,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 74,888,400.00 | 64,560,980.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 73,519,000.00 | 63,209,260.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 158,400.00 | 158,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 742,500.00 | 742,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 169,000.00 | 161,820.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 49,500.00 | 39,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 250,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1545200.00 | 1160400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,545,200.00 | 1,160,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 56932500.00 | 56932500.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 56,932,500.00 | 56,932,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 56,932,500.00 | 56,932,500.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 444,386,100.00 | 428,686,167.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 439,586,100.00 | 423,756,167.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 439,586,100.00 | 423,756,167.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 4,800,000.00 | 4,930,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,800,000.00 | 4,930,000.00 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 22 | 22 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18 | 18 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|--|----------|-----------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 56,858,907.00 | 1,340,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 56,858,907.00 | 1,340,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 56,788,907.00 | 1,340,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 470,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 470,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 56,788,907.00 | 00.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 56,788,907.00 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 870000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 870,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 70,000.00 | 0.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 70,000.00 | 00.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 70,000.00 | 00.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 12,091,658.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 12,091,658.00 |
| 220001 | Барилга байгууламж | | 12,091,658.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 56,858,907.00 | 13431658.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 56,858,907.00 | 13,431,658.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 12,091,658.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 56,788,907.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 70,000.00 | 1,340,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Мөнхтулга 2022 оны 01 дугаар сарын 27-ноос 2022 оны 02 дугаар сарын 09-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь “Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг хэрэгжүүлэх замаар байгалийн унаган төрхийг хадгалан үлдээх, биологийн төрөл зүйлүүд, ховор амьтан, ургамлыг хамгаалах, амьдрах орчныг хадгалан үлдээх, улмаар даян дэлхийд гарч буй байгаль орчны өөрчлөлтийг хянах, мэдээлэл солилцох, судалгаа шинжилгээ явуулах,

байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх оновчтой менежментийг бүрдүүлэх” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Биологийн олон янз байдал тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, популяцийн тоо толгойг тэнцвэрт хэмжээнд хадгалах Засгийн газрын шийдвэр болон харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Бэлчээрийн дарамтыг бууруулах, газрын тогтвортой менежментийг бий болгох*
- *Ойн нөөц, ус, усны орчныг хамгаалах, зохистой ашиглах тэнцвэрт байдлыг хадгалах*
- *ТХГН-ийн сүлжээг өргөтгөх замаар голлох экосистемүүдийг хамгаалалтад авч үйл ажиллагааг нь сайжруулах*
- *Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан замаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах*
- *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 492,090.5 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 9,841.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд

гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,873.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,844.0 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант онд авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,002.0 мянган төгрөг болж 1,269.0 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 40,808.3 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр 365.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 42,442.2 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 692,600.4 мянган төгрөг, оны эцэст 553,716.1 мянган төгрөг болж 138,884.3 мянган төгрөгөөр буурсан нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 29,252.9 мянган төгрөгийн балансын үнэтэй 7,566.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг шилжүүлсэн, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөс 12,091.7 мянган төгрөгийн байгаль хамгаалагчийн байр барьж өгсөн хөрөнгийг хүлээн авч орлогод бүртгэсэн тайлант оны хуримтлагдсан элэгдэл 73,352.8 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 606,562.1 мянган төгрөг байсан оны эцэст 565,718.1 мянган төгрөг болж тайлант онд 40,844.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -271,569.2 мянган төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 444,386.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 444,386.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 444,386.1 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 444,386.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 439,586.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,800.0 мянган төгрөгийг өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 423,756.7 мянган төгрөг, өөрийн орлогоор 4,930.0 мянган төгрөг нийт 428,686.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 428,686.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 428,686.7 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь Цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 3961.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 457.3 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 538.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 384.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 10,327.4 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар Хөшөөт хөгжил сангаас байгаль хамгаалагчийн байр барихтай холбоотой 12,091.7 мянган төгрөг, хууль бус ангийн торгуулийн орлогоор 1,000.0 мянган төгрөг, үнэт цаасны орлогоор 340.0 мянган төгрөг нийт 13,431.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 13,431.7 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 135 мэдээллийг хугацаандаа оруулсан, 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа илэрсэнгүй.

4.1 Залруулсан алдаа

1. Аудитаар залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт, албан шаардлага бичигдээгүй

4.3 Зөвлөмж

Тус байгууллагад хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Аудитаар алдаа илрээгүй болно.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР